

“Хай Би Ойл” ХК-ийн 2014 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Нэр: “Хай Би Ойл” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ 110 тоот

Утас: 99098989, 99095728

Улсын бүртгэлийн мэдээлэл: Улсын бүртгэлийн № 9010001063, регистр № 2615134

“Хай Би Ойл” ХК нь 2007.04.19-ний өдрийн Монголын Санхүүгийн Зохицуулах Хорооны 41 тоот шийдвэрээр хувьцаат компани болсон. Одоогоор нийт 9’234’268 ширхэг хувьцаатай байна.

“Хай Би Ойл” хувьцаат компани нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөр “Ажилласан техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр”-ийн төслийг хэрэгжүүлэхэд зарцуулсан ба Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйлдвэрийн зориулалттай 0,8 га газар дээр 200м блокон хашаа, 600 м³ эзэлхүүнтэй цэвэр бохир тосны агуулах, ачиж буулгах 2 эстакад, үйлдвэрлэлийн зориулалттай цэвэр усны гүний худаг, цахилгааны дэд станц, 336 м² талбай бүхий үйлдвэрийн барилга, сард 200 тн ажилласан тос боловсруулах технологийн дэвшилтэт тоног төхөөрөмжүүдийг барьж байгуулан Байгаль орчны яамаар үйлдвэрт Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгүүлэн батлуулж, Мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулснаар үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлж 2008.10.27-ны өдөр олон нийтэд зарлан албан ёсоор нээлтээ хийсэн билээ.

“Хай Би Ойл” ХК нь 2008 онд Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 байгууллагад шалгарч байсан. 2010 онд МХАҮТ-аас жил бүр зохиогддог “Органик Монгол ба ногоон бүтээгдэхүүн үзэсгэлэн”-д өөрсдийн дахин боловсруулсан гидрийн тосоор оролцон “Шилдэг ногоон бүтээгдэхүүн”-ээр шалгарч өргөмжлөл, мөн “Органик Монгол ба ногоон бүтээгдэхүүн үзэсгэлэн 2010”-гийн шилдэг оролцогчоор шалгарсан. 2012 онд Монголын маркетинг, менежментийн хүрээлэнгээс зохион байгуулагддаг “Гранд Экспо” үндэсний бизнес фестивалд оролцож, хэрэглэгчдийн дунд явуулсан санал асуулга, мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтээр “Хүнд, хөнгөн үйлдвэрийн ТОП-5 шинэ технологи нэвтрүүлэгч үйлдвэр” номинацийн 2-р байрын шагналаар шагнагдаж байсан.

Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:

Тайлант хугацаанд үйлдвэрт 1-3 дугаар саруудад ээлжит урсгал засвар үйлчилгээг сайтар хийсний үр дүнд тос боловсруулах тоног төхөөрөмжид ноцтой болон гэнэтийн гэмтэл зөрчил гараагүй жигд, хэвийн ажиллаж байна. Тайлант

хугацаанд буюу 6-р сарын 30-ны өдрийг хүртэл бид 327'018л техникийн хаягдал тосыг гэрээтэй компаниудаас хуримтлуулан авч өмнөх оны үлдэгдлийн хамт нийтдээ 885'180л түүхий эд цуглуулж авсан. Үүнээс 304'130л мазут боловсруулан мөн үлдэгдлийн хамт 305'197л мазутыг нэг литр тутмыг 720₮ – 900₮-ийн хооронд гэрээний дагуу борлуулснаар 266'978'080₮-ийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Өмнөх 2013 оны эхний хагас жилд ямар ч борлуулалт хийгдээгүй ба бүтэн жилийн хугацаанд нийтдээ 160'000 литр мазутыг борлуулсан. Үүнээс харахад 2014 онд мазутын борлуулалт эрс сайжирсан хэдий ч цаашид борлуулалтыг дахин нэмэгдүүлэх тал дээр арга хэмжээг авч ажиллаж байна.

Тосны үйлдвэрлэлийн түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний нөөц 2014.06.30-ны өдөр дараах байдалтай байна.

Түүхий эдийн нөөц 581'180 литр

Боловсруулсан тос /Мазут/ 25'393 литр

Хөрөнгө оруулалт, хэрэгжүүлж буй төсөл:

“Хай Би Ойл” ХК Малайз улсад бүртгэлтэй өөрийн охин компани болох НВОil (L) Berhad компанийг БНАСАУ-ын нийслэл Пхеньян хотод нээсэн.

НВОil (L) Berhad компани нь БНАСАУ-ын үндэсний газрын тосны хайгуулын компани “Korea Oil Exploration Corp” компанитай хамтарсан төслийн нэг хэсэг болох БНАСАУ-ын эх газрын газрын тосны хайгуулын үйл ажиллагааг явуулах зорилготой юм.

Пхеньян хот дахь Янгадо зочид буудалд байрлах геологийн мэдээллийн төвийг байгуулсан ба шаардлагатай тоног техник хангамж болон программ хангамжийг суурилуулж улмаар БНАСАУ-д газрын тос байгалийн хийн чиглэлээр хийгдсэн бүх хайгуулын мэдээллүүд, геологи геофизикийн болон техникийн мэдээллүүдийг олж авч нэгтгэх, дахин боловсруулах, хөрвүүлэх ажлуудыг хийж байна.

“Хай Би Ойл” ХК БНАСАУ-д газрын тос байгалийн хийн чиглэлээр хийгдэж байсан эх газрын хайгуулын геологийн болон геофизикийн мэдээллийг каталогжуулж, дижиталжуулах ажлыг ирэх саруудад дуусгахаар зорьж байгаа ба техникийн мэдээллийн сангийн өрөөг байгуулах ажлыг энэ жилийн сүүлээр дуусгах төлөвлөгөөтэй. Энэхүү ажил нь цаашид эх газрын газрын тосны хайгуулын тендер зарлахад чиглэгдэж байгаа юм.

“Хай Би Ойл” ХК нь БНАСАУ дахь газрын тосны хайгуулын салбарт Квентин Ригби (Mr. Quentin Rigby) – г төслийн удирдлага, зөвлөхөөр томилон ажиллуулж байна. Квентин Ригбийн талаар товч дурдахад:

Кэмбрижийн Их Сургуулийн Квийнс коллежийг Геологийн магистараар төгссөн. Их Британийн Дурэмийн Их Сургуульд (Durham University) Геофизикийн шинжлэх ухааны Докторын зэрэг хамгаалсан. Тэрээр баруун Европ, Африк, Азийн орнуудад газрын тосны хайгуул болон олборлолтын салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай.

Тэрээр Shell, British Petroleum, Hess компаниудад геологич, геофизикчээр ажиллаж байсан бөгөөд энэ үеэр Их Британийн Хойд тэнгис болон Зүүн өмнөд Азийн хайгуулын төслүүдийн багцыг удирдаж ажиллаж байсан туршлагатай. Сүүлийн 15 жил гаруйн

хугацаанд тэрээр Австрали, Мянмар, Папуа Шинэ Гвиней болон Тайланд улсад шинээр гарч ирж буй хайгуул олборлолтын компаниудыг амжилттай ажиллахад голлох үүрэгтэйгээр оролцсон.

Хийгдсэн засварын ажлууд:

Нэгдүгээрт, үйлдвэрт ашиглагдаж байгаа бохир болон боловсруулсан тос нөөцлөх сав, агуулах дутмаг байгаа. Хоёрдугаарт, үйлдвэрлэлийн гол дамжлага болох мембранан шүүр 4 дэх жилдээ ашиглагдаж солих болсон. Гуравдугаарт, 2014 онд богино хугацаанд 1'700'000 литр мазут нийлүүлэх болсон зэрэг дээрх шалтгаануудаас үүдэн гидрийн шингэн болон хэвний тос үйлдвэрлэх ажлыг түр зогсоож мазутыг түлхүү үйлдвэрлэх болсон. Тэгэхээр, тосны нөөцийн сав, паркийг нэмэгдүүлж, шүүр сольсноор дээрх асуудлыг бүрэн шийдхээс гадна боловсруулж буй бүтээгдэхүүний төрөл ч нэмэгдэнэ гэж үзэж байгаа.

Бид эрчим хүч бага зарцуулах, богино хугацаанд тосоо сэлгэн халаах чадвартай уур үүсгэгч төхөөрөмж захиалж хийлгэхээр гэрээ байгуулан 2014 оны 1, 2 дугаар саруудад захиалгын дагуу угсралт, суурилуулалтыг хийлгэсэн. Үүнд уур үүсгэгчийн тенг болон гэр труба, тэжээлийн кабель, уурын трубаны трасс, шугам хоолойг шинэчилсэн байгаа. Үүний үр дүнд V-MAT-ийн уур үүсгэгчийн бохир тос халаах явц удаан байсныг 2-3 дахин түргэтгэсний зэрэгцээ цахилгаан эрчим хүчийг ч тодорхой хэмжээгээр хэмнэх болсон.

Үйлдвэрийг гэнэтийн гал түймэр болон хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрийн орчныг камержуулах, гал хулгайн дохиолол суурилуулахаар мэргэжлийн байгууллагуудаас судалгаа хийсний дүнд гэрээ хэлцэл хийгдсэн. Үүнд: үйлдвэрийн доторх болон гадна орчинг бүхэлд нь хянах өдөр, шөнийн 7 ширхэг камер сурилуулах, гэнэтийн гал гарах, шөнө оройн цагаар хулгай орхоос сэргийлж дуут дохиолол суулгаж суурилуулахаар төлөвлөсөн.

Үйлдвэрийн хашаанд ажилчдын байр, хувцас солих өрөө, хооллох өрөө, уулзалтын өрөө зэрэг оффис болон ажилчдын амрах байр сав дутмаг байдаг тул өвөл зуны зориулалт бүхий 4*12 м-ийн хэмжээтэй зөөврийн оффис болон ажилчдын байр захиалж хийлгэсэн. Тус оффис нь ажилчдыг халуун хүйтэн, ус бороотой үед ч тав тухтай орчинд хооллож ажиллах таатай нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Одоогоор зөөврийн байр сууцыг хүлээж авхаас өмнө үйлдвэрийн хашаанд 13*9 м-ийн хэмжээтэй бетонон талбайг цутгах ажил явагдаж байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Компани их хэмжээний ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй, урт богино хугацааны зээл аваагүй болно.

Тайлант хугацаанд түрээс, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 5, ажил үйлчилгээ үзүүлэх 4, худалдах худалдан авахтай холбогдолтой 3 ширхэг гэрээнүүдийг байгуулсан байна. Санхүүгийн үйл ажиллагаа, ажил үйлчилгээ үзүүлэхтэй холбогдолтой гэрээ тус бүрийг компанийн ТУЗ-р шийдвэрлүүлж гарах зардлыг батлуулан ажиллаж байна.

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгаланы шимтгэлийн тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, татвар, нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

2014 оны эхний хагас жилд 242,707,345 төгрөгийн орлоготой, 130,493,117 төгрөгний өртөгтэй, цалин хөлсний зардалд 128,955,843 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 16,764,261 төгрөг, албан томилолтын зардал д 17,827,141, мэргэжлийн үйлчилгээний зардалд 45,143,805, бусад үйл ажиллагааны зардалд 17,909,841 зарцуулсан байна. ХХОАТатварт 14,278,533 төгрөг, ОАТатварт 3,874,039 төгрөг, газрын төлбөрт 780,120 төгрөг, ҮХЭХАТ –т 3,437,493 төгрөг, НӨАТ-т 3,824,834 төгрөг төлсөн байна.

2014 оны 2-р улирлын санхүүгийн тайлангийн хураангуй:

№	а.Үлдэгдлийн тэнцэл	01 сарын 01	06 сарын 30
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,479,200	2,285,343
2	Дансны авлага	45,329	276,478
3	Бусад авлага	383,223	499,901
4	Бараа материал	85,215	65,888
5	Урьдчилж төлсөн зардал тооцоо	104,881	108,381
6	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,097,848	3,235,990
7	Үндсэн хөрөнгө	1,423,050	1,404,098
8	Биет бус хөрөнгө	4,475	3,666
9	Урт хугацаат хөрөнгө оруулалт	4,962,300	5,011,300
10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,389,825	6,419,064
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,487,673	9,655,054
12	Дансны өглөг	241,294	244,519
13	Татварын өр	5,551	17,047
14	Богино хугацаат зээл	8,564,345	8,510,345
15	Хүүний өглөг	335,024	335,024
16	Бусад богино хугацаат өр төлбөр	14,722	63
17	Өр төлбөрийн нийт дүн	9,160,936	9,106,998
18	Хувийн өмч	923,427	923,427
19	Нэмж төлөгдсөн капитал	561,194	561,194
20	Хуримтлагдсан ашиг	(1,157,884)	(936,565)
21	Эздийн өмчийн дүн	326,737	548,056
22	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	9,487,673	9,655,054
	б.Орлого үр дүнгийн тайлан		

23	Борлуулалтын орлого (цэвэр)		242,707
24	Борлуулалтын өртөг		130,493
25	Нийт ашиг (алдагдал)		112,214
26	Хүүгийн орлого		12,323
27	Бусад орлого		0
28	Ерөнхий ба удирдлагын зардал		223,522
29	Санхүүгийн зардал		2,464
30	Бусад зардал		615
31	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		324,615
32	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		222,552
33	Орлогын татварын зардал		1,232
34	Татварын дараах ашиг (алдагдал)		221,319

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	FIREBIRD GLOBAL MASTER HOLDINGS-2	28,29%
2	БИДИСЕК ХК	24,69%
3	FIREBIRD MONGOL HOLDINGS A.S.A	16,76%
4	ХҮДРЭЭ ӨЛЗИЙСАЙХАН	5,02%
Нийт		74,76%

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын тайлан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Лхагвадорж, Ө.Хүдрээ, Б.Пүрэвбаатар, Кэйт Беннетт, Ж.Эрдэмбилэг, хараат бус гишүүдээр Х.Батхишиг, М.Батсүрэн, түр гишүүнээр Д.Даянбилгүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Лхагвадорж, Гүйцэтгэх захирлаар Ө.Хүдрээ,Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ж.Энхцэцэг нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргачийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн дарга	дээд

2	Өлзийсайхан овогтой Хүдрээ	Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн ердийн гишүүн,	дээд
3	Баярсайхан овогтой Пүрэвбатаар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Санхүү эрхэлсэн захирал	дээд
4	Кэйт Беннетт	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
5	Жүгдэрнамжил овогтой Эрдэмбилэг	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Халтар овогтой Батхишиг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
7	Мажигсүрэн овогтой Батсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
8	Сий Кок Хенг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Данзан овогтой Даянбилгүүн	ТУЗ-ийн түр гишүүн	дээд
10	Жаргал овогтой Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд

“Хай Би Ойл” ХК 2014 оны 04 сарын 22-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2014 оны 05 сарын 22-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А.Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Х.Батхишиг, Б.Пүрэвбаатар, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Батхишигийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Ж.Эрдэмбилэг, Х.Батхишиг, М.Батсүрэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Ж.Эрдэмбилэг, М.Батсүрэн, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.